

НЭГ. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо : 2021 оны 10 дугаар сарын 18
Тендер шалгаруулалтын нэр: Тэсрэх материалын агуулах
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202112458

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр Тэсрэх материалын агуулахын зураг төсөв, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх техникийн тодорхойлолт болон бусад холбогдох материалыг хавсаргасан болно.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50,000.00 /тавин мянган/ төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 онуудын гүйцэтгэсэн борлуулалтын дундаж хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 50 %-аас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 50 сая төгрөгөөс багагүй байна.

Аудитын дүгнэлт ирүүлэх жилийн тоо: 2020 он

Тусгай зөвшөөрөл: Уул уурхайн зураг төсөл боловсруулах

Туршлага: Уул уурхайн үйлдвэрийн зураг, төсөл боловсруулах, тэсрэх материалын барьж байгуулсан 2-аас доошгүй жилийн туршлагатай байх,

Тендерийн хамт 1 000 000 төгрөгийн дүнтэй цахим системээр тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 10:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 10:05 цагт цахим системээр нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: Зөвшөөрөхгүй.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. Тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс авч болох ба тендерийн тодруулгыг Захиалагч www.tender.gov.mn хаягаар цахим хэлбэрээр хүлээн авна.

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ